

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/016/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЖАРГАЛАНТ  
ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: [adiyasuren@audit.gov.mn](mailto:adiyasuren@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК захирал:

Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/197  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЖАРГАЛАНТ  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
В.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус цэцэрлэгийн бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн 4,919.4 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сумын ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 4,293.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,721.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал акталж 1,935.7 мянган төгрөгийн уурын зуухыг сумын ЗДТГ-т шилжүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 87,94 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

  
4126020238

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>205,631,198.24</b> | <b>100,762,352.27</b> |
| <b>31</b>  | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | <b>147,078,282.30</b> | <b>38,326,506.69</b>  |
| 312        | Банкинд байгаа бэлэн мөнгө  | 147,078,282.30        | 38,326,506.69         |
| 3121       | Төгрөг  | 147,078,282.30        | 38,326,506.69         |
| 31211      | Төрийн сангийн харилцах   | 147,078,282.30        | 38,326,506.69         |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | <b>58,552,915.94</b>  | <b>62,435,845.58</b>  |
| 354        | Хангамжийн материал   | 58,552,915.94         | 62,435,845.58         |
| 35420      | Аж ахуйн материал   | 210,000.00            | -                     |
| 35460      | Хүнсний материал  | -                     | 398,400.00            |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 58,342,915.94         | 62,037,445.58         |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>209,979,265.30</b> | <b>190,786,321.08</b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | <b>209,979,265.30</b> | <b>190,786,321.08</b> |
| 392        | Биет хөрөнгө  | 202,985,265.30        | 183,792,321.08        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 226,253,148.60        | 226,253,148.60        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | (53,117,235.18)       | (62,837,874.42)       |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 49,185,422.33         | 48,527,489.33         |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | (39,907,485.65)       | (39,024,792.65)       |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 27,292,770.59         | 26,682,892.19         |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | (22,787,442.04)       | (23,616,738.97)       |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 31,626,740.00         | 26,687,940.00         |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | (18,252,551.35)       | (21,593,141.00)       |
| 39217      | Ном   | 2,691,898.00          | 2,713,398.00          |
| 393        | Биет бус хөрөнгө  | 6,994,000.00          | 6,994,000.00          |
| 39301      | Програм хангамж   | 50,000.00             | 50,000.00             |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | (50,000.00)           | (50,000.00)           |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 6,994,000.00          | 6,994,000.00          |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>415,610,463.54</b> | <b>291,548,673.35</b> |
| <b>4</b>   | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | -                     | -                     |
| <b>41</b>  | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | -                     | -                     |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>415,610,463.54</b> | <b>291,548,673.35</b> |
| 51         | Засгийн газрын хувь оролцоо   | 415,610,463.54        | 291,548,673.35        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 70,053,124.95         | 70,053,124.95         |
| 51101      | Өмч: - төрийн   | 70,053,124.95         | 70,053,124.95         |
| 512        | Хуримтлагдсан үр дүн  | 230,454,995.73        | 106,505,922.13        |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 230,454,995.73        | 230,567,712.32        |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | -                     | (124,061,790.19)      |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү                                      | 115,102,342.86        | 114,989,626.27        |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>415,610,463.54</b> | <b>291,548,673.35</b> |

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он              | Тайлант он            |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                               | <b>636,062,234.00</b> | <b>571,007,506.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>608,867,534.00</b> | <b>34,199,106.00</b>  |
| 120         | Нийтлэг татварын бус орлого  | 10,859,434.00         | 34,199,106.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 3,204,000.00          | -                     |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                    | 3,204,000.00          | -                     |
| 120017      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө                     | 4,244,000.00          | -                     |
| 120018      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал                     | 3,411,434.00          | 34,199,106.00         |
| 122         | Тусламжийн орлого  | 598,008,100.00        | -                     |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                 | <b>27,194,700.00</b>  | <b>536,808,400.00</b> |
| 1310        | Улсын төвлөрсөн төсвөөс  | -                     | 506,671,200.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | -                     | 506,671,200.00        |
| 1320        | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       | 27,194,700.00         | 30,137,200.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 27,194,700.00         | 30,137,200.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                   | <b>570,422,443.26</b> | <b>695,046,796.19</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>570,422,443.26</b> | <b>695,046,796.19</b> |
| 210         | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 569,778,224.06        | 694,768,024.61        |
| 2101        | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    | 402,895,272.70        | 476,165,358.61        |
| 210101      | Үндсэн цалин   | 267,446,716.74        | 293,237,590.96        |
| 210102      | Нэмэгдэл   | 128,785,743.96        | 173,491,817.65        |
| 210104      | Урамшуулал   | 6,662,812.00          | 9,435,950.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>50,682,553.52</b>  | <b>57,149,650.00</b>  |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 34,817,973.58         | 38,865,700.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 4,071,922.70          | 4,572,700.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 2,002,973.37          | 2,287,200.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 2,600,258.20          | 2,287,200.00          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 7,189,425.67          | 9,136,850.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>24,550,480.80</b>  | <b>26,858,428.42</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 3,704,720.80          | 5,308,668.42          |
| 210302      | Түлш, халаалт  | 18,029,760.00         | 18,029,760.00         |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 2,816,000.00          | 3,520,000.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>8,041,460.00</b>   | <b>12,646,230.36</b>  |
| 210401      | Бичиг хэрэг  | 3,537,510.00          | 3,886,750.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 3,245,350.00          | 4,161,550.00          |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | -                     | 43,500.00             |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,258,600.00          | 2,833,360.00          |
| 210408      | Бараа материал акталсны зардал                                       | -                     | 1,721,070.36          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>55,641,800.00</b>  | <b>59,503,800.00</b>  |
| 210502      | Хоол, хүнс   | 55,641,800.00         | 59,503,800.00         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>2,077,000.00</b>   | <b>37,199,106.00</b>  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 77,000.00             | -                     |
| 210604      | Урсгал засвар  | 2,000,000.00          | 37,199,106.00         |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>2,840,000.00</b>   | <b>250,000.00</b>     |
| 210702      | Дотоод албан томилолт  | 2,840,000.00          | 250,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>4,477,630.00</b>   | <b>5,466,787.00</b>   |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,374,630.00          | 3,328,000.00          |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1,008,000.00          | 1,008,000.00          |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 95,000.00             | 1,130,787.00          |
| 2109        | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 18,572,027.04         | 19,528,664.22         |

**Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

|        |   |                      |                         |
|--------|---|----------------------|-------------------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                 | 71,500.00            | -                       |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх               | 1,396,600.00         | 314,220.00              |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол              | 17,103,927.04        | 19,214,444.22           |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                         | 644,219.20           | 278,771.58              |
| 2133   | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг     | 644,219.20           | 278,771.58              |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг                           | 644,219.20           | 278,771.58              |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>       | 65,639,790.74        | (124,039,290.19)        |
| 225    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>          | -                    | 22,500.00               |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                  | -                    | 22,500.00               |
| 4      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b> | -                    | <b>(22,500.00)</b>      |
| 5      | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                  | <b>65,639,790.74</b> | <b>(124,061,790.19)</b> |

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

|             |  |                       | /төгрөгөөр/             |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| Код         | Үзүүлэлт   | Өмнөх он              | Тайлант он              |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                              | <b>625,202,800.00</b> | <b>536,808,400.00</b>   |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>598,008,100.00</b> | -                       |
| <b>122</b>  | <b>Тусламжийн орлого</b>   | <b>598,008,100.00</b> | -                       |
| 122001      | Хандив тусламж /дотоод/  | 598,008,100.00        | -                       |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                       | <b>27,194,700.00</b>  | <b>536,808,400.00</b>   |
| 1310        | Улсын төвлөрсөн төсвөөс  | -                     | 506,671,200.00          |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | -                     | 506,671,200.00          |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                      | <b>27,194,700.00</b>  | <b>30,137,200.00</b>    |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/        | 27,194,700.00         | 30,137,200.00           |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                               | <b>556,457,304.22</b> | <b>645,516,175.61</b>   |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>556,457,304.22</b> | <b>645,516,175.61</b>   |
| 210         | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 555,813,085.02        | 645,237,404.03          |
| 2101        | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил  | 401,844,060.70        | 476,165,358.61          |
| 210101      | Үндсэн цалин   | 267,126,716.74        | 293,237,590.96          |
| 210102      | Нэмэгдэл   | 128,405,743.96        | 173,491,817.65          |
| 210104      | Урамшуулал   | 6,311,600.00          | 9,435,950.00            |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                      | <b>50,682,553.52</b>  | <b>57,149,650.00</b>    |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 34,817,973.58         | 38,865,700.00           |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 4,071,922.70          | 4,572,700.00            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 2,002,973.37          | 2,287,200.00            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 1,945,861.62          | 2,287,200.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 7,843,822.25          | 9,136,850.00            |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                           | <b>24,550,480.80</b>  | <b>26,858,428.42</b>    |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 3,704,720.80          | 5,308,668.42            |
| 210302      | Түлш, халаалт  | 18,029,760.00         | 18,029,760.00           |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 2,816,000.00          | 3,520,000.00            |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>55,095,300.00</b>  | <b>59,945,700.00</b>    |
| 210502      | Хоол, хүнс   | 55,095,300.00         | 59,945,700.00           |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                   | <b>2,000,000.00</b>   | <b>3,000,000.00</b>     |
| 210604      | Урсгал засвар  | 2,000,000.00          | 3,000,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>            | <b>545,000.00</b>     | <b>1,790,787.00</b>     |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 545,000.00            | 1,790,787.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                     | <b>21,095,690.00</b>  | <b>20,327,480.00</b>    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 15,594,580.00         | 15,072,910.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 5,501,110.00          | 5,254,570.00            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>644,219.20</b>     | <b>278,771.58</b>       |
| 2133        | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг                                | 644,219.20            | 278,771.58              |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 644,219.20            | 278,771.58              |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b>68,745,495.78</b>  | <b>(108,707,775.61)</b> |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | -                     | <b>44,000.00</b>        |
| 22          | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | -                     | 44,000.00               |
| 2200        | Дотоод эх үүсвэрээр  | -                     | 44,000.00               |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | -                     | 44,000.00               |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | -                     | <b>(44,000.00)</b>      |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | <b>68,745,495.78</b>  | <b>(108,751,775.61)</b> |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | <b>78,332,786.52</b>  | <b>147,078,282.30</b>   |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | <b>147,078,282.30</b> | <b>38,326,506.69</b>    |

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/**

| Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн     | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-----------------------|---|
| <b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>70,053,124.95</b>            | <b>115,102,342.86</b> | <b>164,792,415.19</b> | <b>349,947,883.00</b>                   |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | -                     | -                                       |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>70,053,124.95</b>            | <b>115,102,342.86</b> | <b>164,792,415.19</b> | <b>349,947,883.00</b>                   |
| Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | 65,662,580.54         | 65,662,580.54                           |
| <b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>70,053,124.95</b>            | <b>115,102,342.86</b> | <b>230,454,995.73</b> | 415,610,463.54                          |
| <b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>70,053,124.95</b>            | <b>115,102,342.86</b> | <b>230,454,995.73</b> | 415,610,463.54                          |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | 112,716.59            | 112,716.59                              |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>70,053,124.95</b>            | <b>115,102,342.86</b> | <b>230,567,712.32</b> | 415,723,180.13                          |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | -                               | (112,716.59)          | -                     | (112,716.59)                            |
| Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | (124,061,790.19)      | (124,061,790.19)                        |
| <b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>70,053,124.95</b>            | <b>114,989,626.27</b> | <b>106,505,922.13</b> | 291,548,673.35                          |

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт  | Төлөвлөгөө            | Гүйцэтгэл             | Зөрүү                 | Хувь         |
|-------------|---|-----------------------|-----------------------|-----------------------|--------------|
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | <b>670,841,500.00</b> | <b>536,529,628.42</b> | <b>134,311,871.58</b> | <b>80.0</b>  |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | <b>30,137,200.00</b>  | <b>29,858,428.42</b>  | <b>278,771.58</b>     | <b>99.1</b>  |
| 132001      | Орон нутгийн төсвөөс  | 30,137,200            | 29,858,428            | 278,771.58            | 99.1         |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨВЛӨРСӨН САНХҮҮЖИЛТ</b>                               | <b>509,580,000.00</b> | <b>506,671,200.00</b> | <b>2,908,800.00</b>   | <b>99.4</b>  |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                               | 509,580,000           | 506,671,200           | 2,908,800.00          | 99.4         |
| 120004      | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                           | 131,124,300.00        | -                     | 131,124,300.00        | 0.0          |
| 1200042     | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих                                  | 131,124,300.00        |                       | 131,124,300.00        | 0.0          |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                        | <b>670,841,500.00</b> | <b>645,281,404.03</b> | <b>25,560,095.97</b>  | <b>96.2</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>670,841,500.00</b> | <b>645,281,404.03</b> | <b>25,560,095.97</b>  | <b>96.2</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | <b>670,841,500.00</b> | <b>645,281,404.03</b> | <b>25,560,095.97</b>  | <b>96.2</b>  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                        | <b>493,731,800.00</b> | <b>476,165,358.61</b> | <b>17,566,441.39</b>  | <b>96.4</b>  |
| 210101      | Үндсэн цалин  | 306,948,800           | 293,237,591           | 13,711,209.04         | 95.5         |
| 210102      | Нэмэгдэл  | 177,314,900           | 173,491,818           | 3,823,082.35          | 97.8         |
| 210104      | Урамшуулал  | 9,468,100             | 9,435,950             | 32,150.00             | 99.7         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>           | <b>61,385,500.00</b>  | <b>57,149,650.00</b>  | <b>4,235,850.00</b>   | <b>93.1</b>  |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 41,636,300            | 38,865,700            | 2,770,600.00          | 93.3         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 4,937,300             | 4,572,700             | 364,600.00            | 92.6         |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 2,468,600             | 2,287,200             | 181,400.00            | 92.7         |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 2,468,600             | 2,287,200             | 181,400.00            | 92.7         |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 9,874,700             | 9,136,850             | 737,850.00            | 92.5         |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | <b>27,137,200.00</b>  | <b>26,858,428.42</b>  | <b>278,771.58</b>     | <b>99.0</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 5,607,400             | 5,308,668             | 298,731.58            | 94.7         |
| 210302      | Түлш, халаалт   | 18,029,800            | 18,029,760            | 40.00                 | 100.0        |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 3,500,000             | 3,520,000             | (20,000.00)           | 100.6        |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>61,057,000.00</b>  | <b>59,945,700.00</b>  | <b>1,111,300.00</b>   | <b>98.2</b>  |
| 210502      | Хоол, хүнс  | 61,057,000            | 59,945,700            | 1,111,300.00          | 98.2         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | <b>3,000,000.00</b>   | <b>3,000,000.00</b>   | <b>-</b>              | <b>100.0</b> |
| 210604      | Урсгал засвар   | 3,000,000             | 3,000,000             | -                     | 100.0        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>3,209,700.00</b>   | <b>1,790,787.00</b>   | <b>1,418,913.00</b>   | <b>55.8</b>  |
| 210806      | Мэдээлэл технологийн үйлчилгээ                                  | 3,209,700             | 1,790,787             | 1,418,913.00          | 55.8         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | <b>21,320,300.00</b>  | <b>20,371,480.00</b>  | <b>948,820.00</b>     | <b>95.5</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 15,828,400            | 15,072,910            | 755,490.00            | 95.2         |
| 210902      | Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал                             | 5,491,900             | 5,298,570             | 193,330.00            | 96.5         |
| <b>4</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>         |                       | <b>147,078,282.30</b> |                       |              |
| <b>5</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>        |                       | <b>38,326,506.69</b>  |                       |              |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 958,100.5 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 4 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 44.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна.
- Үндсэн хөрөнгийн шинж агуулаагүй 34,199.1 мянган төгрөгийн бараа материалыг буруу бүртгэсэн байна.
- Урсгал үйл ажиллагааны 506,671.2 мянган төгрөгийн санхүүжилтийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн.
- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үлдэгдлийн 415,610.4 мянган төгрөгийг тайлагнаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 5,262.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 5,703.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.2 Залруулаагүй зөрчил

Аудитаар нийт 5,262.3 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

#### 5.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 5,262.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь МУЗГ-ын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 237 дугаар тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" журмыг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон журмыг дагуу өгөөгүй зөрчлийг дахин гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### 5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

### **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 243 ширхэг 53,149.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**  
**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| д/д | Алдааны товч утга   | Нийт алдаа |                  | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                  | Үүнээс     |                  |              |     |
|-----|---|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|-----|
|     |   | Тоо        | Дүн              | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн              | Залруулсан |                  | Залруулаагүй |     |
|     |   |            |                  |                                   |     |                          |                  | Тоо        | Дүн              | Тоо          | Дүн |
| 1   | Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 44.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна. | 1          | 1,619.8          |                                   |     | 1                        | 1,619.8          | 1          | 1,619.8          |              |     |
| 2   | Үндсэн хөрөнгийн шинж агуулаагүй 34,199.1 мянган төгрөгийн бараа материалыг буруу бүртгэсэн байна.                          | 1          | 34,199.1         |                                   |     | 1                        | 34,199.1         | 1          | 34,199.1         |              |     |
| 3   | Урсгал үйл ажиллагааны 506,671.2 мянган төгрөгийн санхүүжилтийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн.                     | 1          | 506,671.2        |                                   |     | 1                        | 506,671.2        | 1          | 506,671.2        |              |     |
| 4   | Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үлдэгдлийн мянган төгрөгийг тайлагнаагүй.   | 1          | 415,610.4        |                                   |     | 1                        | 415,610.4        | 1          | 415,610.4        |              |     |
|     | <b>Дүн</b>  | <b>4</b>   | <b>958,100.5</b> |                                   |     | <b>4</b>                 | <b>958,100.5</b> | <b>4</b>   | <b>958,100.5</b> |              |     |

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Үүнээс        |     |                 |                |          |          |                                      |     |   |     |
|-----|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|----------|----------|--------------------------------------|-----|---|-----|
|     |  |             |                | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|     |  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн      | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| 1   | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 5,262.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1           | 5,262.3        |               |     | 1               | 5,262.3        | -        | -        |                                      |     |   |     |
| 2   | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.  | 1           | -              |               |     | -               | -              | 1        | -        |                                      |     |   |     |
| 3   | Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 243 ширхэг 53,149.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.       | 1           | -              |               |     | -               | -              | 1        | -        |                                      |     |   |     |
|     | <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>5,262.3</b> |               |     | <b>1</b>        | <b>5,262.3</b> | <b>2</b> | <b>-</b> |                                      |     |   |     |

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 51-20810579-ТӨА-2026/016/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэг нь тайлант онд Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 5,262,300.00 (Таван сая хоёр зуун жаран хоёр мянга гурван зуун) төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 237 дугаар тогтоолын 1-т Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3000 (гурван мянга) төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4100 (дөрвөн мянга нэг зуун) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан нормативын дагуу цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг тооцож олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант цэцэрлэгийн эрхлэгч В.Отгонжаргал, нягтлан бодогч Д.Эрдэнэбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨССӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)